**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ**
**2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх (эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах) нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох.** | | | | | | | |
| 1. | Зорилт-1.1 Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ. | Улсын төсөв. 586.0 сая төгрөг | Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоо бүрдэх. | Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоо бүрдэх бодлогын баримт бичиг, хэрэгжүүлэх арга хэмжээний суурь нөхцөл бүрдсэн. | 100% | Ковид-19 цар тахлын үед иргэдийг биеийн тамирын дасгал хөдөлгөөн, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн дархлааг дэмжих, эрүүл зөв хооллолт, зөв дадал хэвшилтэй иргэдийг бий болгох зорилгоор Эрүүл мэндийн цахим гүйлт, Дасгал хөдөлгөөнөө хийцгээе, Цахим гимнастрада, Иргэдийн наадам-21, Өртөөт марафон, цуврал хичээл, зөвлөмжүүдийг 21 аймаг, 9 дүүргийн БТСХороо, Эрүүл мэндийн салбарын 22, ивээн тэтгэгч 2, спорт клуб 15, төрийн болон төрийн бус нийт 70 гаруй байгууллагатай хамтран биеийн тамирын арга хэмжээг цахимаар болон спорт зааланд зохион байгуулсан. Цахим арга хэмжээнд 80,250 хүн, спорт заал болон гадаа арга хэмжээнд 2291 багийн 19541 иргэд хамрагдсан. Эдгээр арга хэмжээг зохион байгуулах зардал 313.843.000 | 76% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. | |
| 2. | Арга хэмжээ-1.1.1 Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин бүрдүүлэх. | Улсын төсөв. 100.0 сая.төгрөг | Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар) сорилд хамрагдсан A, B, C үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулсан хувь. | 53 хувь | 54.5 хувь | Даргын 2021 оны А/155 дугаар тушаалаар Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил авах аргачлал, сорилын стандартыг боловсронгуй болгох ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг насны ангилалд хурд, хүч, авхаалж самбаа, тэнцвэр, тэсвэрийг авах аргачлалыг шинэчлэн боловсруулах сорил авах аргачлалыг статик болон динамик байдлаар авах, үнэлгээ, зөвлөмжийг боловсруулах талаар хэлэлцсэн. БНСУ-д хэрэгждэг бие бялдрын түвшин тогтоох сорилын хөтөлбөрийн бие бялдрын түвшин тогтоох сорилын стандарт, дасгалын жор, сорилын төвийн судалгаа хийж, төвийн тоног төхөөрөмж, сорил авах аргачлалыг Солонгос-Монгол хэлэнд орчуулж өөрийн орны онцлогт тохируулан байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн “Бие бялдрын түвшин тогтоох үйл ажиллагааны стандарт”-ыг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан техникийн хороогоор хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. | 70% |
| 3. | Арга хэмжээ-1.1.2 Биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн | Улсын төсөв. 0 төгрөг | 2021 онд Мэдээллийн сангийн үйл ажиллагаа эхлүүлсэн байна. | ТЭЗҮ батлагдсан. | Мэдээллийн сангийн үйл ажиллагаа эхэлсэн байна. | Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ын хэрэгжилтийн хүрээнд цахим сангийн сервер, тоног төхөөрөмжийг | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | технологийн бааз, платформ бий болгож хэрэгжүүлнэ. | | | | | Үндэсний Дата төвд байршуулж, шилжүүлснээр салбарын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, системийн хөгжүүлэлт хийх нөхцөл бүрдсэн.<br>Салбарын мэдээллийн нэгдсэн цахим сангийн бүрдүүлэлт, ашиглалтын ажил хийгдэж байгаатай холбогдуулан олон талт хэрэглэгчдийн сургалт, нэвтрүүлэлтийг үе шаттай зохион байгуулан, спортын цол зэргийн мэдээллийг цахим санд байршуулан холбогдох шаардлагад нийцүүлж байна. Цахим санд 21 спорт холбоодын холболтыг хийж холбогдсон холбоодын веб болон спортын цол олголт, тэмцээн, наадмын дэд системийн цэсийн төрийн үйлчилгээ үзүүлэх хөгжүүлэлт тогтмол хийгдэж байна. Даргын 2021 оны А/301 дүгээр тушаалаар “Биеийн тамир, спорт-цахим салбар арга хэмжээ”г батлан 2022-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | |
| 4. | Арга хэмжээ-1.1.3 Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгоно. | Улсын төсөв. 150.0 сая төгрөг | Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх гэрээ байгуулан дүгнэсэн байна. | Эрх зүйн орчин бүрдсэн. | 77 ажил | Үндэсний шигшээ багт сонгогдсон 22 төрлийн спортын холбоо, 240 дасгалжуулагч, тамирчдыг ажлын байраар хангаж санхүүгийн дэмжлэг үзүүлж байна..Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд сонгогдоогүй даам, туялзуур сэлэм, усан спортын төрлөөр 47,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Иргэдийн дунд дасгалаар дархлааг дэмжих, зөв дадал хэвшилтэй иргэдийг бий болгох зорилгоор эрүүл зөв хооллолт, үндэсний наадгай, иог, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахим гүйлт, алхалт, дугуй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэр бүлийн орчинд дэмжих арга хэмжээ зохион байгуулж төрийн бус байгууллагатай 63.373.000 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ байгуулан 18 хүнийг түр ажлын байраар хангасан. | |
| 5. | Арга хэмжээ -1.1.4 Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Улсын төсөв. 300.0 сая төгрөг | Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг цахим хэлбэрээр авах техник, хэрэгслээр хангагдсан байна. | Судалгаа хийгдсэн бөгөөд сорил авах 2 хувилбарын төслийг боловсруулсан. | Сорилыг цахим хэлбэрээр авах техник, хэрэгслээр аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагыг хангах. | Байгууллагын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд сорилыг цахим хэлбэрээр авах техник, хэрэгслийг тусгаж ажилласан боловч төсөвгүйн улмаас худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно. | 30% |
| 6. | Арга хэмжээ -1.1.5 Иргэд эрүүл, аюулгүй орчинд, өөрийн бие бялдарт тохирсон арга зүйн дагуу спортоор хичээллэх нөхцөлийг спортын сургалт-дасгалжуулалт, орчин, хэрэглэл материалын стандарт, түүнийг хэрэгжүүлэх спортын сургалтын жишиг хөтөлбөрөөр | Улсын төсөв. 16.0 сая төгрөг | Батлагдсан стандарт, жишиг сургалтын хөтөлбөрийн тоо | Стандарт 13, хөтөлбөрийн төсөл 2 | Спортын төрлийн стандарт-6, сургалтын хөтөлбөр-2 батлуулах. | БТСУХ-ны даргын 2020 оны А/102 дугаар тушаалаар стандарт боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсэг нь бадминтон, жүдо, дардас, спортын бүжиг, мөсний шагай зэрэг 5 спортын төрлийн стандартыг, волейбол, ширээний теннис, буудлага спортын 3 төрлийн сургалтын хөтөлбөрийн боловсруулалтыг тус тус хийж байна. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрдүүлэх, стандарт, хөтөлбөрийг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | | | | | | |
| 7. | Арга хэмжээ-1.1.6 Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлнэ. | Улсын төсөв. 0 төгрөг | Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санд мэдээлэл байршуулах төрийн байгууллага, спортын холбоодын тоо | ТЭЗҮ батлагдсан. | Төрийн байгууллага 30, спортын холбоо 15 | Байгууллагын sport.gov.mn болон харьяа 31 байгууллага, статистикийн дэд систем болон үндсэн админ cpanel эрхийн нийт 34 домэйн хаягийг үүсгэн үндсэн сервер рүү холболтыг хийлгэн ажилласан бөгөөд харьяа 31 байгууллага болон 15 холбоодод мэдээллийн цахим санд нэвтрэх эрх үүсгэсэн. | 100% |
| 8. | Арга хэмжээ-1.1.7 Биеийн тамирын арга зүйчд мэргэжлийн зэрэг олгох, мэргэшүүлэх давтан сургалтыг зохион байгуулна. | Улсын төсөв. 20.0 сая.төгрөг | Биеийн тамирын арга зүйчийн мэргэшүүлэх давтан сургалтын хөтөлбөр батлах | | Биеийн тамирын арга зүйчийн мэргэшүүлэх давтан сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлагдсан байна. | БТСУХ-ны даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/167 дугаар тушаал “Биеийн тамирын арга зүйчийн мэргэшүүлэх давтан сургалтын хөтөлбөр”-ийг баталсан.<br>Биеийн тамирын арга зүйчид төгсөлтийн дараах мэргэжлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг даргын А/167 тоот тушаалаар батлуулж сургалт явуулах их дээд сургуулийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангасан сонгон шалгаруулах, арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох ажлыг явуулах эрх зүйн үндэслэл манай байгууллагад олгогдоогүй байна. Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт орсноор эрх зүйн үндэс бүрдэнэ. | 90% |
| 9. | Зорилт 1.2 Иргэдэд үйлчлэх спортын | Улсын төсөв. | Иргэдэд үйлчлэх спортын | Спортын зориулалтын | 100% | Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн | 72% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина. | 3,483.7 сая төгрөг<br><br>БНХАУ-ын буцалтгүй тусламж. 54,700.0 сая төгрөг | зориулалтын стандарт талбай, олон улсын жишигт нийцсэн спортын барилга, байгууламж. | стандарт талбай, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламж барих ажлын явц хийгдэж байна. | | хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламж барих ажлын явц үргэлжилж байна | |
| 10. | Арга хэмжээ 1.2.1 Спортын төв ордон барих ажлыг эхлүүлнэ. | БНХАУ-ын буцалтгүй тусламж | ТЭЗҮ-д тулгуурлан санхүүжилтийг эх үүсвэрийг шийдвэрлэсэн байна. | Схем зураг хийгдсэн. | Ажлын даалгавар боловсруулна. | Спортын төв ордон барих ажлын даалгаврыг 2015 онд боловсруулсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 онд БНХАУ-д хийсэн албан айлчлалын хэлэлцэх асуудлын жагсаалтад Спортын төв ордныг тус улсын буцалтгүй тусламжаар шинэчлэн барих асуудлыг оруулах хүсэлтийг 2021 оны 1/317 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т, 2021 оны 1/318 дугаартай албан бичгээр Гадаад хэргийн яаманд тус тус хүргүүлсэн. | 50% |
| 11. | Арга хэмжээ 1.2.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолборыг ашиглалтад оруулна. | БНХАУ-ын буцалтгүй тусламж. 54,700.0 сая төгрөг | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь, | Зураг төсөв хийгдэн, газрын асуудал шийдвэрлэгдсэн. | 27 хувь | БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 20.4 сая ам долларын өртөгтэй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт, цогцолбор нь нийтдээ 19,567.0м2 талбай бүхий 7 давхар барилга бөгөөд зочид буудал, 200м тойрог бүхий манеж, гадна талдаа 400м тартайн зам, спортын 10 төрөлд зэрэг хичээллэх боломжтой бэлтгэлийн заалтай олон улсын стандартад нийцсэн тусгай тоноглол бүхий ордон байна. Тус ордон Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Чингис Хаан ОУ-ын Нисэх буудлын нисэх, буух зурвасын баруун талд 10 га газарт баригдаж | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна. Цар тахлын улмаас барилга угсралтын ажил удаашралтай байна. | |
| 12. | Арга хэмжээ 1.2.3 Налайх, Баянзүрх, Баянгол дүүргийн иргэдэд үйлчлэх усан бассейн бүхий спортын цогцолборын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулна. | Улсын төсөв. 3,400.0 сая төгрөг | Усан бассейн бүхий спортын цогцолбор ашиглалтад орсон байна. | Барилга угсралтын ажил 80-90 хувьтай явагдаж байна. | Баянгол дүүргийн спорт цогцолбор | Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ барилга угсралтын ажлыг 2022 оны 01 дүгээр сард Улсын комисс ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. | 100% |
| 13. | Арга хэмжээ 1.2.4 Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна. | Улсын төсөв. 83.7 сая.төгрөг | Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар батлагдсан байна. | Сургуулийн спорт заалны зураг төсөл боловсруулах ажилд 27.9 сая төгрөг тусгагдсан. | Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар боловсруулна. | Сум болон аймгийн төвд баригдах спортын заал, усан бассейн бүхий спорт цогцолборыг нэг маягийн зураг төсөл Барилгын хөгжлийн төвд байдаг бөгөөд түүнийг шинэчлэн сайжруулах боломжийг судалж байна. | 50% |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2.<br>Спортын сургалт-дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх.** | | | | | | | |
| 14. | Зорилт 2.1. Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын | Улсын төсөв. 140.0 сая.төгрөг | Үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоо бүрдсэн байна. | Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлэх бодлогын баримт бичиг бүрдсэн. | 100% | Даргын 2021 оны А/160 дугаар тушаалаар “Үндэсний уламжлалт спортыг сурталчлах, цахим контент бий болгох” ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг баталсан. Ажлын хэсэг үндэсний спортын холбоодоос санал авч нэгтгэн боловсруулж байна. | 67% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтолцоог хөгжүүлнэ | | | | | | |
| 15. | Арга хэмжээ 2.1.1 Үндэсний уламжлалт спортын төв байгуулах, үндэсний багтай болно. | Улсын төсөв. 0 төгрөг | Үндэсний спортын төвийн ТЭЗҮ батлагдсан байна. | - | Ажлын даалгавар боловсруулна. | Үндэсний спортын төвд 8 үндэсний спортын задгай талбайг байгуулахаар төлөвлөсөн ба шагайн харваа, мөсөн сурын спортын холбооноос зураг төслийн даалгаварт тусгуулах талбайн стандарт хэмжээ, ерөнхий төлөвлөлтийн зургийн талаарх мэдээлэл ирүүлсэн. Морин уралдаан, жороо морь, ширээний шагай, халх сурын харваа, бариуд сурын харваа, морин харваа, уран уургач, эмнэг сургагч, тэмээн поло спортын холбоод зураг төслийн даалгаварт тусгуулах санал, мэдээллийг боловсруулалт хийгдэж байна. Үндэсний спортын төрлүүдээр зохион байгуулагдах олон улсын тэмцээн, наадам Ковид-19 цар тахлын улмаас хойшилсон учир энэхүү арга хэмжээ хойшилсон. | 50% |
| | Арга хэмжээ -2.1.2 Улсын хэмжээнд иргэдийн дунд нийтийн спортын төрөлжсөн наадмыг 2-4 жил тутамд зохион байгуулна. | Улсын төсөв. 0 төгрөг | Иргэдийн наадам зохиогдсон байх | - | Иргэдийн наадмын спортын төрлийг тогтоох, бэлтгэл ажил хангах. | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 268 дугаар “Спортын наадмыг хойшлуулах тухай” тогтоолоор “Монголын бүх ард түмний спортын XV наадам”-ыг 2022 онд зохион байгуулахаар тогтсон. Уг наадмыг үндсэн 20 төрөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэний спортын 5 төрлөөр зохион байгуулахаар тогтсон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16. | Арга хэмжээ -2.1.3 Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгох, үндэсний спортын холбоодын хөгжлийг дэмжинэ. | Улсын төсөв. 80.0 сая.төгрөг | Брэнд наадмын шийдвэр гарсан шийдвэр, спортын хөгжлийг дэмжих хувь | Үндэсний уламжлалт спортын холбоодын хөгжлийг дэмжиж 50 хувь | НҮБ-ын ЮНЕСКО-гийн Уламжлалт спорт, тоглоом наадгайн олон улсын зөвлөлтэй хамтран ажиллах, наадам зохион байгуулах шийдвэр гаргуулах, Үндэсний уламжлалт спортын холбоодын хөгжлийг дэмжиж 55 хувьд хүргэх, | Үндэсний спортын тоглоом наадгайн төрөл болох шагайгаар тоглох спорт тоглоомыг түлхүү зохион байгуулах шийдвэрийг НҮБ-ын ЮНЕСКО-гийн Уламжлалт спорт, тоглоом наадгайн олон улсын зөвлөлөөс гаргуулахаар ажиллаж байна.<br>Үндэсний шагайн харваа, мөсөн сур спортын 2 төрлөөс ажлын даалгаварт тусгуулах санал авч олон улсын брэнд наадмыг зохион байгуулах хөтөлбөрийн төслийн боловсруулалт хийгдэж байна. | 50% |
| 17. | Арга хэмжээ 2.1.4 Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд сурталчлан таниулж, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулна. | Улсын төсөв. 60.0 сая.төгрөг | Контентын тоо | - | Уламжлалт спорт, тоглоом наадгайн олон улсын брэнд наадмыг бий болох таниулах, контентын үзэл баримтлал, өв сангийн эх үүслийн тухай, контентын баримт бичиг боловсруулах, ажлыг эхлүүлэх | Даргын 2021 оны А/160 дугаар тушаалаар Үндэсний уламжлалт спорт сурталчлах цахим контентын ажлын даалгавар боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг уламжлалт спорт, тоглоом наадгайн наадмын контентын шагайн харвааны спортын төрлөөр ажлын даалгавар боловсруулж байна. Өөрийн орны өвөрмөц шинж чанарыг сурталчлах, орчин үеийн хүүхэд, залуучуудад үндэсний спортын өв соёл, зан заншил тэдгээрийн үүсэл гарлыг таниулах, гадаадын иргэдэд сурталчлах, үндэсний спортоор дамжуулан улс орны эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг олшруулах зорилгоор Үндэсний спортын төрлөөс сонголт хийж | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Шагайн харвааны танилцуулга контент бэлтгэсэн. | |
| 18. | Зорилт-2.2 Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах. | Токио олимп сан 400,0 төгрөг<br><br>Улсын төсөв. 10,9 тэр.төгрөг | Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоо хөгжиж тамирчдын олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадвар. | “Рио-2016” Олимп, Паралимпийн наадамд спортын 9 төрөлд 43 эрх авч оролцсон | 100% | Засгийн газрын 2021 оны 156 дугаар тогтоолоор Токио-2020 зуны олимп, паралимпийн наадамд оролцох эрхийн болзол хангасан Үндэсний шигшээ багийн тамирчин тус бүр 10 000 000 сая.төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулал олгох, Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний цалинг 2021 оны 06 дугаар сарын 1-ний өдрөөс, 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл дуустал хугацаанд 1 500 00 сая.төгрөг, цаашид тамирчны цалинг сард 1 200 000 сая. төгрөг, дасгалжуулагчийн цалинг сард 1 500 000 төгрөг хүртэл тогтоох шийдвэр гарсан. | 91% |
| 19. | Арга хэмжээ -2.2.1 Спортын амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад мөнгөн шагнал олгох, олимпын наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчдад сар бүр урамшуулал олгоно. | Улсын төсөв. 2,0 тэр.төгрөг | Тамирчин, дасгалжуулагчдад мөнгөн шагнал олгогдсон байна. | 1573 тамирчин, дасгалжуулагчдад 2,720,435.0 төгрөг олгогдсон. | Тамирчин, дасгалжуулагчдад мөнгөн шагнал олгогдсон байна. | Даргын 2021 оны А/12 дугаар тушаалаар Олимп, дэлхийн аваргын тэмцээнээс медаль хүртсэн тамирчдад олгох 2021 оны урамшуулалд нийт 58 тамирчин түүний дасгалжуулагч нарт 1.584.000.000 төгрөг олгохоор шийдвэрлэсэн. Мөн Боксын залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн /2021-190/, Шатрын спортын Их мастер цол /2021-190/, Чөлөөт бөхийн залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн /2021-292/, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Токио 2020” Олимп /2021-240/, Паралимпийн наадамд /2021-292/ медаль хүртсэн тамирчид болон түүний дасгалжуулагч нарт олгох мөнгөн шагналын Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан батлуулж, нийт 9 дасгалжуулагч, 12 тамирчинд 517.500.000 төгрөг олгогдсон. | |
| 20. | Арга хэмжээ-2.2.2 Сургалт-дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулна. | Улсын төсөв. 70.0 сая.төгрөг | Сургалт-дасгалжуулалтад хамрагдсан байна. | Мэргэшүүлэх сургалтын эрх зүйн орчин бүрдсэн, сургалт зохион байгуулах сургууль, багш сонгогдсон. | 60 дасгалжуулагч сургалтад хамрагдах. | БТСУХ-ны даргын 2021 оны А/74 дүгээр тушаалаар “Дасгалжуулагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хичээлийн хөтөлбөр”-ийг батлагдан “Төгсөлтийн дараах дасгалжуулагчийн мэргэшүүлэх сургалт”-ыг МУБИС-ын харьяа Биеийн тамирын сургуультай хамтран Аймаг, нийслэл, дүүргийн спортын газар, хороо, спортын холбоо, клубийн багш, дасгалжуулагчдыг мэргэжил, арга зүйгээр хангах сургалтад хамруулах 53 хүний сургалтын зардалд 68,9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Аймаг, дүүргийн 30, спортын холбоодын 23 биеийн тамирын дээд сургуулийг бакалавраар төгссөн төгсөгчид 20 кредитийн 7 хичээлд хамрагдсан. | 100% |
| 21. | Арга хэмжээ -2.2.3 Үндэсний шигшээ багийн спортын төрөл, тамирчин сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион | Улсын төсөв. 0 төгрөг | Үндэсний шигшээ багийн зуны спортын төрөл, тамирчин сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна. | Зуны олимпын спортын 12, өвлийн олимпын спортын 3, зуны паралимпын 6, өвлийн паралимпын 1, нийт 22 спортын төрөлд Үндэсний шигшээ багийн сонгон | Үндэсний шигшээ багийн зуны спортын төрөл, тамирчин сонгон шалгаруулалтыг зохион байгуулах. | БСШУС-ын сайдын 2019 оны А/167 дугаар тушаалаар “Үндэсний шигшээ баг бүрдүүлэх, тамирчин сонгон шалгаруулах журам”-ын дагуу Үндэсний шигшээ багт спортын 22 төрөл, үүнээс зуны спортын 17 төрлөөр, 230 тамирчин, дасгалжуулагч улсын төсвөөс цалин, тэмцээн уралдаан, бэлтгэл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулалтаар хангана. | | | шалгаруулалтыг зохион байгуулсан. | | сургалтын зардлыг санхүүжүүлж байна. Насанд хүрэгчид, залуучуудын Үндэсний шигшээ багийн дасгалжуулагчид нь сургалт дасгалжуулалтын жилийн болон олон улсын зэрэглэлийн тэмцээний төлөвлөгөөг тус бүр Олон улсын спортын холбоодоос баталсан хуваарьтай уялдуулан Спортын анагаах ухаан эрдэм шинжилгээний төвөөс гаргасан судалгаанд тулгуурлан микро, мезо, макро цикл тус бүрээр нарийвчлан төлөвлөн хэрэгжүүлдэг. Мөн Спортын анагаах ухаан, сэтгэл зүй, хоол зүй, эрдэм шинжилгээний 4 төрлийн баг 22 спортын төрөл дээр мэргэжил арга зүйгээр ханган ажилласнаар жингийн спортын төрлүүдэд хүндрэл бага гарч үр өгөөж өссөн. | |
| | Арга хэмжээ -2.2.4 Хүүхэд, залуучуудын спортын авьяасыг илрүүлж шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх хүрээнд үндэсний хэмжээнд спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнийг жил тутам зохион явуулах, зохион байгуулалтыг оновчтой болгоно. | Улсын төсөв 950.0 сая.төгрөг | 2 жил тутамд зохион байгуулсан байна. | Спортын наадам зохион байгуулсан | Хүүхдийн болон Бүх ард түмний спортын наадмын зохион байгуулалтын тогтолцоог цаг үеийн нөхцөл стандартын дэглэмийг мөрдөж, журмын хүрээнд шинэ түвшинд зохион байгуулах. | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 268 дугаар “Спортын наадам хойшлуулах тухай” тогтоолоор "Монголын бүх ард түмний спортын XV наадам"-ыг 2022 онд, "Монголын хүүхдийн спортын VII наадам"-ыг 2023 онд зохион байгуулахаар тус тус хойшлуулсан. | 90% |
| 22. | Арга хэмжээ -2.2.5 Спортын сургалт-дасгалжуулалтын | Улсын төсөв 0 төгрөг | Өсвөр үеийн шигшээ багийн тамирчдаас түүвэр | 21 аймаг, 9 дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн сургалт- | Өсвөр үеийн шигшээ багийн тамирчдаас түүвэр | Нийслэл болон 21 аймгийн өсвөрийн тамирчдын бие бялдрын хөгжил, бэлтгэл сургуулилтын төлөвлөлтийн | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагаанд спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээ хийх болон өсвөр үеийн шигшээ багт хүрч ажиллах дэд бүтцийг сайжруулна. | | судалгаа, сорил авах, дасгалжуулагчдын сургалт-дасгалжуулалтын арга зүйд дүн шинжилгээ хийгдсэн байна. | дасгалжуулалтыг тогтмол хянах, зөвлөмж, дүгнэлт өгөх цахим платформ үүссэн. | судалгаа, сорил авах, дасгалжуулагчдын сургалт-дасгалжуулалтын арга зүйд дүн шинжилгээ хийнэ. | талаарх суурь судалгааг гарган үр дүнд дүн шинжилгээ хийх ажлын бэлтгэлийг хангасан. Энэхүү арга хэмжээг орон нутгаас эхлэхээр төлөвлөн Архангай, Баянхонгор аймгийн өсвөрийн шигшээ багийн тамирчдаас эрдэм шинжилгээний сорил, тест авах авч 4 үндсэн сэдвээр онол, практик хосолсон сургалт зохион байгуулж 64 дасгалжуулагч, биеийн тамирын арга зүйч нарыг хамруулсан.<br>Аймаг, нийслэл, дүүрэг, улс болон олон улсын тэмцээнд онцгой амжилт гаргасан тамирчдыг БСШУС-ын сайдын 2016 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Үндэсний шигшээ баг бүрдүүлэх, тамирчин сонгон шалгаруулах журам”, “Үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу тухайн төрлийн спортын холбоодын санал, сонгон шалгаруулалтыг үндэслэн Насанд хүрэгчдийн Үндэсний шигшээ багийг спортын 19 төрлөөр 30 дасгалжуулагч, 84 тамирчин, Залуучуудын шигшээ багийг спортын 14 төрөлд, 3 дасгалжуулагч, 55 тамирчны орон тоотой төсвөөс цалин, тэмцээн уралдаан бэлтгэл сургалтын зардал санхүүжилтийг хариуцан ажиллаж байна. | |
| 23. | Арга хэмжээ -2.2.6 Спортын холбоодын урт хугацааны бодлого | Улсын төсөв. Төслийн санхүүжилт | 5 спортын холбооны урт хугацааны бодлого төлөвлөлтийн | | 5 спортын холбооны урт хугацааны бодлого төлөвлөлтийн | Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2021 оны А/228 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Спортын холбоодын урт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөлтийг боловсруулна. | | судалгаа хийгдэж, бодлого төлөвлөлтийн баримт бичиг батлагдсан байх. | | судалгаа хийгдэж, бодлого төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах. | болон дунд хугацааны бодлого төлөвлөлтийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг, хоёрдугаар хавсралтаар спортын холбоодын урт болон дунд хугацааны бодлого төлөвлөлтийн судалгаа хийх, бодлогын баримт бичиг боловсруулах удирдамжийг, гуравдугаар хавсралтаар шаардагдах хөрөнгийн задаргааг тус тус баталсан.<br>Спортын холбоодын урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсгийн хурлыг 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж 2021 онд стратеги төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллах 5 спортын холбоог сонгосон.<br>Үүнд:<br>• Үндэсний спортын холбоодоос **Мөсний шагайн холбоо**<br>• Багийн спортын холбоодоос **Волейболын холбоо**<br>• Халз тулааны спортын холбоодоос **Самбо бөхийн холбоо**<br>• Хэмжигдэхүүнтэй спортын холбоодоос **Тэшүүрийн холбоо**<br>• Паралимпийн спортын холбоодоос **Суугаа волейболын холбоо** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Стратеги төлөвлөгөө боловсруулан спортын холбоодод хүргүүлсэн. байна. | |
| 24. | Арга хэмжээ -2.2.7 Өвөл, багийн, болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны ба шинэ тутам хөгжиж буй спортын төрлүүдээр чадамжийг дээшлүүлэх сургалт зохион байгуулна. | Улсын төсөв. 100.0 сая.төгрөг | Сургалтын тоо | Сургалт-6, | Сургалт-10 | Сургалт 1. БТСУХ-ны даргын 2021 оны А/21 дүгээр тушаалаар “Спортын холбоодын ажил үйлчилгээ, үйл ажиллагааг коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг хэрэгжүүлэх удирдамж” батлагдаж хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн 37 байгууллагад зөвлөгөө, мэдээлэл өгч цахим сургалт зохион байгуулсан.<br>Сургалт 2. Биеийн тамир, спортын салбарын цахим мэдээллийн нэгдсэн санг үүсгэх, программ хангамжийг хөгжүүлэх ажлын хүрээнд 29 спортын холбооны цахим сан хариуцсан 40 гаруй ажилтныг 4 өдрийн 32 цагийн сургалтад хамруулсан.<br>Сургалт 3. “Үндэсний спортын түүхэн өв уламжлал, хөгжлийн хандлага-2” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг ҮБТДС-тай хамтран цахимаар зохион байгуулсан. Уг хуралд дотоодын 14 спортын холбоо, гадаад улс орноос ОХУ, Австрали, БНХАУ-ын ӨМӨЗО, Япон зэрэг орон оролцон илтгэл тавьсан. Илтгэлийг эмхэтгэл болгоход шаардагдах 2,772,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг БТСУХ-ны даргын 2021 оны А/154 дугаартай тушаалаар шийдвэрлэсэн.<br>Сургалт 4. Спортын холбоо нь тухайн спортын төрлийн чиглэсэн үйл | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа явуулах, иргэнд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, тамирчны сургалт-дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, шигшээ баг бүрдүүлэх спортын тэмцээн, спортын төрлийн дагнасан сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд тухайн спортын төрлийн үндэсний стандартыг, сургалт-дасгалжуулалтын хөтөлбөртэй байх нь сэдвээр 40 минутын цахим сургалтыг зохион байгуулж сургалтад 6 спортын холбоодын төлөөлөл оролцсон. | |
| 25. | Арга хэмжээ -2.2.8 Үндэсний шигшээ багийг бүрдүүлж буй спортын холбоодтой хамтран гадаадын өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагчийг урьж ажиллуулна. | Токио олимп сан 400,0 төгрөг | Спортын 4 төрөлд 5-аас доошгүй дасгалжуулагч, тамирчин урьж ажиллуулсан байна | Спортын 4 төрөлд 5 гадаадын дасгалжуулагч, тамирчин ажилласан. | Спортын 4 төрөлд 5-аас доошгүй дасгалжуулагч, тамирчид урьж ажиллуулах. | 1.Үндэсний шигшээ багийг бүрдүүлж буй таеквондогийн спортын төрөлд БНСУ-ын иргэн Хур Ин Ён дасгалжуулагчаар ажиллаж дотоодын цугларалтад 2, гадаадын цугларалтад 1, Олимпын эрх олгох тэмцээнд 1, Азийн аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа тус тус оролцсон.<br>2.Үндэсний шигшээ багийг бүрдүүлж буй жүдо бөхийн спортын төрөлд Япон улсын иргэн Масатоши Нишикидо физотерапист эмчээр дотоод цугларалтад 2, Олимпын эрх олгох тэмцээнд 4 удаа тус тус ажилласан.<br>Мөн жүдо бөхийн спортын тамирчин Саейд Моллай нь дасгалжуулагч Мансур, Касвай Мохаммед дасгалжуулагчийн хамт Олимпын эрх олгох Их дуулга тэмцээнд 4, Олон улсын хамтарсан бэлтгэлд 1, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа тус тус оролцсон.<br>3.Биатлоны спортын төрөлд Беларус улсын иргэн Александр Попов дасгалжуулагчаар Европын 4 цуврал тэмцээнд баг тамирчдаа дасгалжуулан оролцож, Монгол улсад 1 удаа олон улсын сургалтыг удирдан ажилласан. | |
| 26. | Арга хэмжээ -2.2.9 Үндэсний шигшээ багт сонгогдсон спортын холбоодтой гэрээ байгуулж, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгийг холбогдох хууль, журмын дагуу үзүүлэх. | Улсын төсөв. 7,8 тэр.төгрөг | “Токио-2020” олимп, паралимпийн наадамд оролцох эрх авах, оноо цуглуулах тив, дэлхий, олон улсын тэмцээн, гадаад болон дотоодын бэлтгэл цугларалтын нэгдсэн төсөв, төлөвлөгөөний хуваарь батлагдан улсын төсвөөс спортын 22 төрөл, 231 дасгалжуулагч, тамирчдад дэмжлэг үзүүлсэн байна. | 2020 онд спортын 22 төрөл, 231 дасгалжуулагч, тамирчдад 11,154,316,024 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | Спортын 22 төрлийн спортын холбоодтой гэрээ байгуулан нийт спортын 23 төрөл, 231 дасгалжуулагч, тамирчдад дэмжлэг үзүүлэх гэрээ хийн дүгнэж санхүүгийн зарцуулалтын дэлгэрэнгүй болон хураангуй судалгааг гаргаж холбогдох баримтад тулгуурлан дүгнэлт гарсан байна. | “Токио-2020” олимп, паралимпийн наадамд оролцох эрх авах, оноо цуглуулах тив, дэлхий, олон улсын тэмцээн, гадаад болон дотоодын бэлтгэл цугларалтын нэгдсэн төсөв, төлөвлөгөөний дагуу улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулан спортын 22 төрөл, 240 дасгалжуулагч, тамирчдад 9,4 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 27. | Арга хэмжээ -2.2.10 Үндэсний шигшээ багуудын 2021 онд оролцох “Токио-2020” олимп, паралимпийн наадамд оролцох эрх авах, оноо цуглуулах тив, дэлхий, олон улсын тэмцээн, гадаад болон дотоодын бэлтгэл цугларалтын нэгдсэн календарчилсан төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний дагуу оролцох | Улсын төсөв. 0 төгрөг | Батлагдсан календарчилсан төлөвлөгөөний дагуу тив, дэлхийн аварга шалгаруулах, олон улсын тэмцээн, дотоодын болон гадаадын бэлтгэл цугларалтад амжилттай оролцож эрхийн оноо цуглуулах цаашлаад олимп, паралимпийн наадамд спортын 12 төрөлд 46-аас доошгүй эрхийн болзол хангах. | “Токио-2020” Зуны Олимп, Паралимпийн наадамд оролцох спортын 10 төрөлд 16 эрхийн болзол хангаад байна. | Спортын 12 төрөлд 45 эрхийн болзол хангана. “Токио-2020” Олимп, Паралимпийн наадамд оролцсон баг тамирчдын амжилт, оролцох спортын төрөл, авсан эрхийн тоонд тулгуурлан дүгнэх, тив, дэлхий, олон улсын тэмцээн, гадаад болон дотоодын бэлтгэл цугларалтын тоо хэмжээг нэмэгдүүлсэн байдлыг дүгнэх. | “Токио-2020” зуны олимп зуны олимпын спортын 10 төрлөөр 43 эрх,паралимпийн спортын 5 төрөлд 11 эрх нийт 13 төрөлд 31 эрхийн болзол хангасан.<br>Залуучуудын ДАШТ-ээс 2 хүрэл, Мастерс тэмцээнээс 1 хүрэл, Азийн аварга шалгаруулах тэмцээн 5 алт, 5 мөнгө, 12 хүрэл, Их дуулга тэмцээнээс 6 алт, 5 мөнгө, 12 хүрэл, гран-при тэмцээнээс 2 алт, 4 мөнгө, 2 хүрэл, Эрх олгох тэмцээнээс 2 алт, 8 мөнгө, 2 хүрэл, Олимп, паралимпийн наадмаас 1 алт, 1 мөнгө, 3 хүрэл нийт 19 алт,26 мөнгө, 43 хүрэл нийт 91 медаль хүртээд байна. 2020, 2021 оны үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний мэдээ, 2013-2021 онуудын тамирчдын амжилтын дэлгэрэнгүй судалгааг мэдээллийн санд байршуулсан. | 100% |
| **Стратегийн зорилго 3.<br>Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах** | | | | | | | |
| 28. | Зорилт-3.1. Салбарын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилтэд тайлагналтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах | Улсын төсөв. 0 төгрөг | Салбарын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилтийг тайлагналтыг хууль, журмын хүрээнд нэгтгэн боловсруулж тайлагнах. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан. | Хууль, журамд заасан хугацаанд холбогдох газарт хүргэсэн байх. | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааны биелэлт Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн журмын 1 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгээр хавсралтад заасан хугацаанд харьяалах дээд шатны байгууллагад тус тус хүргүүлсэн. | |
